**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/043/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он


Дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал

Утас: 70077734 Цахим хаяг: Nandinjargalg@audit.gov.mn

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр

Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Бадамхатан
Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 339

танай ________ -ны № ________ -т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ТАМИР ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд утааны эсрэг шийдлийг хамтдаа олохоор “Дулаалга” төслийг хэрэгжүүлж, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар эхний ээлжид 30 хувь буюу 7,500.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 3078 байшин сууцыг иргэдтэйгээ хамтран дулаалж, эрчим хүч түлшний хэмнэлттэй ногоон бүстэй болох бэлтгэл ажил хангагдсан байна. Мөн Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, дүүргийн ИТХ-ын 2025 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээний хүрээнд нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 216 алба хаагчид 550.4 сая төгрөгийг олгосон байна.

### Аудитын гол асуудал

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын төсвийг дүүргийн ИТХ-ын 2024 оны 14 дүгээр тогтоолоор 19,423.8 сая төгрөгөөр батлсныг дахин тодотгол хийж, дүүргийн ИТХ-ын 2025 оны 16 дугаар тогтоолоор 16.3 хувиар нэмэгдүүлэн 22,596.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 35.4 хувиар өсгөсөн үзүүлэлттэй байна.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг ... .docx 1426050457

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тайлант онд 245.9 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр дүүргийн 1-24 хорооны гэмт хэрэг, олон нийтийн 26 байцаагчийн цалингийн зардалд 237.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилго нь:

- Бүсчилсэн хөгжлийн бодлого – 91 хувь;
- Хүний хөгжлийн бодлого – 91 хувь;
- Эдийн засгийн бодлого – 89 хувь;
- Ногоон хөгжлийн бодлого – 95 хувь;
- Засаглалын бодлого – 98 хувиар тус тус хэрэгжиж, эдгээр зорилгын хүрээнд төлөвлөсөн 97 зорилт, 342 арга хэмжээний хэрэгжилт 94 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,676,496,580.30** | **5,002,796,008.41** |
| **33** | **АВЛАГА** | 68,294,381.46 | 856,649,170.10 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 2,460,184.64 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 783,337,500.00 |
| **335** | **Бусад авлага** | 68,294,381.46 | 70,851,485.46 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 25,210,000.00 | 25,210,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 43,084,381.46 | 45,641,485.46 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 20,850,234.77 | 1,827,787,500.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 20,850,234.77 | 1,827,787,500.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,587,351,964.07 | 2,318,359,338.31 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 5,177,311.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 693,500.00 |
| 35130 | Эм боох материал | - | 4,483,811.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,587,351,964.07 | 2,313,182,027.31 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 22,478,544.58 | 18,854,003.87 |
| 35420 | Аж ахуйн материал | 31,780,354.99 | 1,031,462,285.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 2,090,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 44,838,003.00 | 30,053,147.04 |
| 35460 | Хүнсний материал | - | 919,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,488,255,061.50 | 1,229,803,091.40 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **77,264,694,760.69** | **75,492,588,487.23** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 77,264,694,760.69 | 75,492,588,487.23 |
| **392** | **Биет хөрөнгө** | 36,266,857,014.00 | 34,417,998,246.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 68,840,140,497.15 | 69,058,079,048.11 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (37,329,990,233.57) | (40,906,664,097.36) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,332,134,740.00 | 1,332,134,740.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (675,289,035.67) | (785,139,609.79) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 5,095,492,712.67 | 4,064,325,972.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,760,438,293.62) | (2,964,388,787.60) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,152,418,356.78 | 1,196,323,451.83 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (746,961,407.82) | (744,565,988.15) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,991,270,027.89 | 6,194,977,324.89 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,633,070,350.34) | (2,027,083,808.51) |
| 39217 | Ном | 1,150,000.53 | - |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40,997,837,746.69 | 41,074,590,241.13 |
| 39301 | Программ хангамж | 105,008,300.00 | 111,979,903.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (82,606,633.31) | (12,825,741.87) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 41,055,436,000.00 | 40,975,436,080.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (79,999,920.00) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **78,941,191,340.99** | **80,495,384,495.64** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **40,664,224.65** | **845,209,127.70** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 40,664,224.65 | 845,209,127.70 |
| **413** | **Өглөг** | 40,664,224.65 | 845,209,127.70 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,503,313.95 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,980,625.00 | 2,980,625.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 33,180,285.70 | 842,228,502.70 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 32,958,739.00 | 842,007,956.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 221,546.70 | 220,546.70 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **78,900,527,116.34** | **79,650,175,367.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 78,900,527,116.34 | 79,650,175,367.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 60,975,541,545.78 | 60,975,541,545.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 60,975,541,545.78 | 60,975,541,545.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 6,759,266,980.80 | 7,510,105,329.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,759,266,980.80 | 6,760,457,077.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 749,648,251.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,165,718,589.76 | 11,164,528,493.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **78,941,191,340.99** | **80,495,384,495.64** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **21,237,953,221.84** | **44,327,560,143.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,107,091,897.40** | **5,023,726,395.07** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,107,091,897.40 | 5,023,726,395.07 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,107,091,897.40 | 5,001,597,195.07 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 32,679,068.00 | 7,442,752.68 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,074,412,829.40 | 4,994,154,442.39 |
| 120005 | Түрээсийн орлого | | 22,129,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **17,130,861,324.44** | **39,303,833,748.68** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 443,350,000.00 | 19,035,912,390.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 12,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 443,350,000.00 | 19,023,412,390.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 16,687,511,324.44 | 20,267,921,358.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,687,511,324.44 | 20,267,921,358.68 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **21,751,063,419.04** | **42,286,893,788.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,751,063,419.04** | **42,286,893,788.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 20,901,252,611.27 | 40,407,860,365.53 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,624,419,941.81 | 8,773,371,981.57 |
| 210101 | Үндсэн цалин | 2,559,457,370.55 | 2,879,510,297.47 |
| 210102 | Нэмэгдэл | 616,529,949.60 | 777,053,357.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 857,095,630.21 | 1,151,578,000.00 |
| 210104 | Урамшуулал | 516,540,279.42 | 492,812,378.19 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,074,796,712.03 | 3,472,417,948.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 887,256,823.25 | 994,572,329.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 654,213,760.53 | 711,775,429.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 74,194,014.18 | 84,351,233.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 29,504,066.47 | 32,429,365.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 22,310,838.78 | 23,577,168.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 107,034,143.29 | 142,439,131.83 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 172,832,088.14 | 326,027,452.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 116,204,919.94 | 200,664,296.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,499,418.83 | 31,882,986.45 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,127,749.37 | 29,480,170.50 |
| 210304 | Байрны түрээс | | 64,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 289,093,891.03 | 584,902,178.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 70,277,270.42 | 144,601,488.73 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 61,680,000.00 | 44,553,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 72,976,050.60 | 83,097,468.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 84,160,570.01 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 126,072,960.99 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 186,576,920.88 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 4,403,389.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 4,403,389.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 94,550,664.00 | 83,155,373.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,175,000.00 |
| 210602 | Тавилга | | 120,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 94,550,664.00 | 81,860,373.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 282,585,228.30 | 254,045,550.40 |
| 210701 | Гадаад албан томилолт | 135,498,208.30 | 196,958,595.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,200,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 147,087,020.00 | 55,886,955.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,898,066,980.37 | 2,083,805,003.09 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,336,927,538.37 | 1,350,953,907.09 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 342,144.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 1,329,382.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 37,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,695,250.00 | 13,479,660.00 |
| 210807 | Газрын төлбөр | 534,444,192.00 | 717,662,910.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,652,446,994.37 | 27,303,577,107.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,630,195,735.18 | 22,215,834,427.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 29,675,000.00 | 63,353,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,992,576,259.19 | 5,024,389,330.81 |
| **212** | **ТАТААС** | 114,360,625.00 | 608,042,700.00 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 114,360,625.00 | 608,042,700.00 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | | 608,042,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 735,450,182.77 | 1,270,990,722.64 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 697,779,382.77 | 1,265,497,722.64 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 258,260,000.00 | 250,821,532.64 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 94,789,382.77 | 18,418,190.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 344,730,000.00 | 996,258,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,670,800.00 | 5,493,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,670,800.00 | 5,493,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(513,110,197.20)** | **2,040,666,355.58** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,924,735,788.14 | 1,291,018,103.98 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,924,735,788.14 | 1,280,999,103.98 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 10,019,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,924,735,788.14) | (1,291,018,103.98) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(2,437,845,985.34)** | **749,648,251.60** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **17,172,449,833.44** | **39,348,048,892.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **30,428,800.00** | **44,215,143.68** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 30,428,800.00 | 44,215,143.68 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 30,428,800.00 | 44,215,143.68 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,428,800.00 | 22,085,943.68 |
| 120005 | Түрээсийн орлого | - | 22,129,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **17,142,021,033.44** | **39,303,833,748.68** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 454,509,709.00 | 19,035,912,390.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 12,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 454,509,709.00 | 19,023,412,390.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 16,687,511,324.44 | 20,267,921,358.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,687,511,324.44 | 20,267,921,358.68 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **16,979,315,303.44** | **38,859,537,036.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,979,315,303.44** | **38,859,537,036.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **16,114,737,206.67** | **36,805,205,801.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,621,045,797.71 | 8,786,633,185.93 |
| 210101 | Үндсэн цалин | 2,532,648,148.22 | 2,889,580,547.38 |
| 210102 | Нэмэгдэл | 638,782,027.36 | 773,052,225.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 849,348,873.87 | 1,133,260,999.95 |
| 210104 | Урамшуулал | 513,652,408.81 | 478,446,766.59 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,086,614,339.45 | 3,512,292,646.82 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 888,665,469.87 | 1,000,593,121.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 636,248,537.09 | 718,455,341.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 74,306,705.99 | 84,173,930.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 29,560,412.37 | 32,340,714.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 22,367,184.68 | 22,420,690.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 126,182,629.74 | 143,202,444.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 172,172,088.14 | 326,027,452.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 115,544,919.94 | 200,664,296.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,414,280.83 | 31,882,986.45 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,212,887.37 | 29,480,170.50 |
| 210304 | Байрны түрээс | - | 64,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 369,365,478.60 | 326,511,290.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 74,260,268.00 | 65,676,845.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,710,000.00 | 58,450,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,354,050.60 | 76,731,684.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 176,041,160.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 125,652,761.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,023,930.00 | 8,887,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,023,930.00 | 8,887,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 116,319,064.00 | 103,226,963.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,700,000.00 | 5,513,090.00 |
| 210602 | Тавилга | | 155,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 101,619,064.00 | 97,558,873.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 294,025,378.30 | 297,308,670.40 |
| 210701 | Гадаад албан томилолт | 137,796,108.30 | 196,958,595.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 1,200,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 156,229,270.00 | 99,150,075.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,102,808,530.87 | 2,496,485,866.61 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,531,151,588.87 | 1,763,634,770.61 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 342,144.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 1,329,382.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 37,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 37,212,750.00 | 13,479,660.00 |
| 210807 | Газрын төлбөр | 534,444,192.00 | 717,662,910.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,546,311,469.18 | 23,459,532,050.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,516,636,469.18 | 23,394,541,700.94 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 29,675,000.00 | 64,990,350.00 |
| **212** | **ТАТААС** | **110,827,914.00** | **-** |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 110,827,914.00 | - |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 110,827,914.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **753,750,182.77** | **2,054,331,235.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 716,079,382.77 | 1,265,500,735.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 258,260,000.00 | 250,821,545.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 94,789,382.77 | 18,418,190.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 363,030,000.00 | 996,261,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,670,800.00 | 788,830,500.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,670,800.00 | 5,493,000.00 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг-нэмэлт | | 783,337,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **193,134,530.00** | **488,511,856.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **193,134,530.00** | **488,511,856.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **193,134,530.00** | **488,511,856.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 193,134,530.00 | 488,511,856.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 193,134,530.00 | 488,511,856.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(193,134,530.00)** | **(488,511,856.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **60,975,541,545.78** | **11,165,718,589.76** | **9,197,112,966.64** | 81,338,373,102.18 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний  бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (2,437,845,985.84) | (2,437,845,985.84) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **60,975,541,545.78** | **11,165,718,589.76** | **6,759,266,980.80** | 78,900,527,116.34 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **60,975,541,545.78** | **11,165,718,589.76** | **4,321,420,994.96** | 78,900,527,116.34 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | 1,190,096.63 | 1,190,096.63 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **60,975,541,545.78** | **11,165,718,589.76** | **6,760,457,077.43** | 78,901,717,212.97 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,  бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | (1,190,096.63) | - | (1,190,096.63) |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 749,648,251.60 | 749,648,251.60 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **60,975,541,545.78** | **11,164,528,493.13** | **7,510,105,329.03** | 79,650,175,367.94 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | 1 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 22,596,853,900 | 20,297,493,311 | 2,299,360,589 | 90% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 22,596,853,900 | 20,297,493,311 | 2,299,360,589 | 90% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 20,993,518,100 | 19,044,492,576 | 1,949,025,524 | 91% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 9,633,541,000 | 8,786,634,186 | 846,906,814 | 91% |
| 210101 | Үндсэн цалин | 3,034,821,000 | 2,889,581,548 | 145,239,452 | 95% |
| 210102 | Нэмэгдэл | 905,299,700 | 773,052,225 | 132,247,475 | 85% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,175,035,000 | 1,133,261,000 | 41,774,000 | 96% |
| 210104 | Урамшуулал | 848,334,500 | 478,446,767 | 369,887,733 | 56% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,670,050,800 | 3,512,292,647 | 157,758,153 | 96% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,276,611,000 | 1,000,593,122 | 276,017,878 | 78% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 834,392,700 | 718,455,342 | 115,937,358 | 86% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 96,029,700 | 84,173,931 | 11,855,769 | 88% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 82,657,200 | 32,340,714 | 50,316,486 | 39% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 31,472,000 | 22,420,690 | 9,051,310 | 71% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 232,059,400 | 143,202,444 | 88,856,956 | 62% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 334,617,600 | 326,027,453 | 8,590,147 | 97% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 153,438,300 | 200,664,296 | (47,225,996) | 131% |
| 210302 | Түлш, халаалт | 60,000,000 | 31,882,986 | 28,117,014 | 53% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 49,179,300 | 29,480,171 | 19,699,130 | 60% |
| 210304 | Байрны түрээс | 72,000,000 | 64,000,000 | 8,000,000 | 89% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 420,622,600 | 329,245,290 | 91,377,310 | 78% |
| 210401 | Бичиг хэрэг | 113,782,600 | 65,676,845 | 48,105,755 | 58% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 69,600,000 | 58,450,000 | 11,150,000 | 84% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 87,240,000 | 76,731,684 | 10,508,316 | 88% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 150,000,000 | 128,386,761 | 21,613,239 | 86% |
| **2105** | **Нормативт зардал** | 10,000,000 | 8,887,200 | 1,112,800 | 89% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,000,000 | 8,887,200 | 1,112,800 | 89% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 456,360,000 | 319,373,419 | 136,986,581 | 70% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 178,241,500 | 153,204,271 | 25,037,229 | 86% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210602 | Тавилга | 104,000,000 | 68,610,275 | 35,389,725 | 66% |
| 210604 | Урсгал засвар | 174,118,500 | 97,558,873 | 76,559,627 | 56% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 450,000,000 | 297,308,670 | 152,691,330 | 66% |
| 210701 | Гадаад албан томилолт | 300,000,000 | 196,958,595 | 103,041,405 | 66% |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,000,000 | 1,200,000 | 18,800,000 | 6% |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 130,000,000 | 99,150,075 | 30,849,925 | 76% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,727,155,000 | 2,606,992,866 | 120,162,134 | 96% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,957,196,300 | 1,849,391,770 | 107,804,530 | 94% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 342,200 | 342,144 | 56 | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,500,000 | 1,329,382 | 170,618 | 89% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000 | 37,000 | 73,000 | 34% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 50,000,000 | 38,229,660 | 11,770,340 | 76% |
| 210807 | Газрын төлбөр | 718,006,500 | 717,662,910 | 343,590 | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,684,610,900 | 5,369,430,370 | 315,180,530 | 94% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,604,610,900 | 5,304,440,020 | 300,170,880 | 95% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 80,000,000 | 64,990,350 | 15,009,650 | 81% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,603,335,800 | 1,253,000,735 | 350,335,065 | 78% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,603,335,800 | 1,253,000,735 | 350,335,065 | 78% |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 301,667,900 | 250,821,545 | 50,846,355 | 83% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,000,000 | 18,418,190 | 61,581,810 | 23% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,221,667,900 | 983,761,000 | 237,906,900 | 81% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 22,596,853,900 | 20,297,493,311 | 2,299,360,589 | 90% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,574,745,100 | 20,267,921,359 | 2,306,823,741 | 90% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 22,574,745,100 | 20,267,921,359 | 2,306,823,741 | 90% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 22,108,800 | 29,571,953 | (7,463,153) | 134% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,108,800 | 29,571,953 | (7,463,153) | 134% |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | - | 0% |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100% |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100% |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 411 | 405 | 6 | 99% |
| 620001 | Удирдах ажилтан | 42 | 39 | 3 | 93% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 127 | 125 | 2 | 98% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30 | 29 | 1 | 97% |
| 620004 | Гэрээт ажилтан | 212 | 212 | - | 100% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **411.00** | **405.00** | 6 | 99% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 132.00 | 127.00 | 5 | 96% |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 7.00 | 7.00 | - | 100% |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 | - | 100% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 30.00 | 29.00 | 1 | 97% |
| 650010 | Гэрээт ажилтан | 212.00 | 212.00 | - | 100% |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 29.00 | 29.00 | - | 100% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **18,247,081,890.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,247,081,890.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 18,234,581,890.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,234,581,890.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 18,234,581,890.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,500,000.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 12,500,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,500,000.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **19,035,912,390.00** |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,035,912,390.00** |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 12,500,000.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,023,412,390.00 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 2,490,663.9 мянган төгрөгийн 8 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд шинээр авсан программ хангамжийн шууд зардлаар бүртгэсэн. | 1 | 57,800.0 | | | 1 | 57,800.0 | 1 | 57,800.0 | | | | |
| Дүүрэгт шинээр байгуулагдсан ОБХ-ийн гаднах хаягийг шилжүүлээгүй, зардалд бүртгэсэн. | 1 | 25,796.1 | | | 1 | 25,796.1 | 1 | 25,796.1 | | | | |
| Ажлаас халагдсан ажилтны ажилгүй байсан хугацааны цалинг шүүхийн шийдвэрээр төсвөөс шилжүүлсэн. | 1 | 17,201.3 | 1 | 17,201.3 | | | 1 | 17,201.3 | | | | |
| Засаг даргын А/397 захирамжаар Шингэрүүлсэн шатдаг хийн баллон түгээх цэг байгуулах гэрээт ажлыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн. | 1 | 1,827,787.5 | | | 1 | 1,827,787.5 | 1 | 1,827,787.5 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг | 1 | 46,411.0 | 1 | 46,411.0 | | | 1 | 46,411.0 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зөрүүтэй тайлагнасан. | | | | | | | | | | | | |
| Хог хаягдлын ОНБ-ийн 6 сарын цалин-гийн НДШ-ийг тайлагнаагүй. | 1 | 2,811.1 | 1 | 2,811.1 | | | 1 | 2,811.1 | | | | |
| ТШЗ-ийн ту-шаалаар бу-сад хангам-жийн мате-риал акталж устгахдаа, уст-галтын акт, тайлангүй. | 1 | 182,856.9 | 1 | 182,856.9 | | | 1 | 182,856.9 | | | | |
| Халиа,тошин шар усны үерээс урьдчи-лан сэргийлэх ажлын тайлан байхгүй. | 1 | 330,000.0 | 1 | 330,000.0 | | | 1 | 330,000.0 | | | | |
| **Дүн** | **8** | **2,490,663.9** | **5** | **579,280.3** | **3** | **1,911,383.6** | **9** | **2,490,663.9** | | | | |

Аудитаар нийт 481,048.2 мянган төгрөгийн 13 зөрчил[2] илэрснээс, төлбөрийг нөхөн төлүүлэх 11,275.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, алдаа зөрчлийг таслан зогсоох 39,988.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 429,784.9 мянган төгрөгийн 9 зөвлөмж өгсөн.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дүүргийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуульд жудо,самбо бөхийн дэвжээ авсан, хөрөн-гийг шилжүүлээгүй. | 1 | 19,800.0 | | | | | 1 | 19,800.0 | | | | |
| Ажиллагсдын сарын нийт ажлын цагаас | 1 | 39,988.3 | | | 1 | 39,988.3 | | | | | | |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 хувиар хэтрүүлэн илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон, мөн ажлын тайлангүй, нэмэгдэл хөлс олгох хуудасгүйгээр нэр бүхий 8 ажилтанд өгсөн. | | | | | | | | | | | | |
| Шатахууныг зардлын тооцооллыг хийдэггүй, жолоочийн авсан шатахууны дүнгээр зардалд бүртгэсэн, шатахууны шаардахыг талоны тоо ширхгээр бичээгүй. | 1 | 44,553.4 | | | | | 1 | 44,553.4 | | | | |
| Дүүргийн төрийн албан хаагчдыг сургалтад хамруулахдаа нэрс, ирцийн бүртгэл байхгүй, өдрийн хоолны мөнгийг давхардуулан олгосон | 1 | 4,375.0 | 1 | 4,375.0 | | | | | | | | |
| Гадаадын зочдод бэлэглэх зорилгоор төсвөөс 6 тооны мал худалдан авсан. | 1 | 6,900.0 | 1 | 6,900.0 | | | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн. | 1 | 222,114.7 | | | | | 1 | 222,114.7 | | | | |
| Санхүүгийн хөрөнгө хариуцсан ажилтнууд шинээр томилогдоход ажлын хэсэг гаргаж, хариуцсан хөрөнгийг хүлээлцэж, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Санхүүгийн тайланд тусгагдсан өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 79,883.1 | | | | | 1 | 79,883.1 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд 43 барилга байгууламжаас, 23 барилгын хувийн хэргийг огт хөтлөөгүй, бусад барилга байгууламжийн хувийн хэргийг 2017 оноос хойш хөтлөөгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| НӨХГ-ын тушаал шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассан. | 1 | 1,489.8 | | | | | 1 | 1,489.8 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд Нийтийн тохижилт, байгууламжууд гэсэн тодорхой бус нэршилтэй, бөөн дүнгээр бүртгэсэн хөрөнгө байна. | 1 | 61,943.9 | | | | | 1 | 61,943.9 | | | | |
| Газрын хэмжээ нь гэрчилгээнээс 596.4 сая төгрөгөөр зөрүү-тэй, НББ-д тусгагд-сан, газрын гэрчилгээг цахим бүртгэлд тусгаж, шинэчлээгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Хагас жилийн хөрөнгийн тоол-логоор бараа мате-риал тоолоогүй, жилийн эцсийн хөрөнгийн тоол-логын тооцоо бодсон баримтыг хавсаргаагүй, ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт тайлант онд гараагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **13** | **481,048.2** | **2** | **11,275.0** | **1** | **39,988.3** | **10** | **429,784.9** | | | | |

Нийцлийн асуудлаар илэрсэн 2,610,786.2 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс 928,877.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 1,681,909.0 мянган төгрөгийн 4 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын төсвийн өмнөх оны төсвөөс 2.5 дахин өсгөж, төсөвлөсөн байна. | 1 | 871,667.9 | | | | | 1 | 871,667.9 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн чиг үүргийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа улсын төсвийн байгууллагад /татварын хэлтэст сургалт, хэлэлцүүлгийн төлбөр, УНТЭ-т зөвлөх эмчийн цалин/-г тус тус шилжүүлсэн. | 1 | 140,000.0 | | | | | 1 | 140,000.0 |
| Тайланд онд зөвхөн Чингэлтэй фестивальд зориулж, төсвөөс мөнгө шилжүүлсэн. | 1 | 219,297.0 | | | 1 | 219,297.0 | | - |
| МУЕС-ийн албан даалгаврыг /2025 оны 05 дугаар/ хэрэгжүүлээгүй. Тухайлбал, буцалтгүй нэг удаагийн тэтгэмж, албан хаагчдын сургалт, багш ажилтнуудын тэмцээн, гадаад томилолт, мөнгөн шөнө арга хэмжээ зэрэг зардлыг төсвөөс гаргаж, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан. | 1 | 346,241.1 | | | | | 1 | 346,241.1 |
| 1-24 хорооны хэсгийн ахлагч 186 ажилтанд, хороодын засаг дарга болон дүүргийн удирдах ажилтнуудад, архивын үзлэгт бэлтгэсэн ажилтнуудад 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж, урамшууллын төсвөөс олгосон. | 1 | 562,404.7 | | | 1 | 562,404.7 | | |
| ӨЭМТ-ийн дарга нарт тайлант жилийн эцэст тус бүр 3 сая төгрөг болон 1-24 хорооны ахмадын эмч нарт сар бүр 2 сая төгрөгийн цалин, урамшуулал өгсөн. | 1 | 324,000.0 | | | | | 1 | 324,000.0 |
| Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх тухай өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1 | 147,175.5 | | | 1 | 147,175.5 | | |
| **Дүн** | **7** | **2,610,786.2** | **-** | **-** | **3** | **928,877.2** | **4** | **1,681,909.0** |